



Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: Олон Улсын Улаанбаатарын Их Сургууль

Хөтөлбөрийн нэр: Сувилахуй

Индекс: D091301

Шинжээчийн баг:

Ахлагч: Д.Солонго

Гишүүд: Б.Энхтуяа

..... Б.Оюунцэцэг

Он сар өдөр: 2020-12-12

Агуулга

Товчилсон үгийн тайлбар	4
I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт	5
II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга	6
III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт	7
Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт	7
Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа	10
Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	14
Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	17
Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	24
Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа	29
Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт	33
IV. Уулзалтад оролцогчдын нэрс	38
I. Багш нарын нэрс	38
II. Оюутнуудын нэрс	38
III. Ажил олгогчдын нэрс	39
IV. Төгсөгчдийн нэрс	39
V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал	40
ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр	
ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр	

Товчилсон үгийн тайлбар

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АШУУИС	Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль
БГД	Баянгол дүүрэг
БЗД	Баянзүрх Дүүрэг
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БСШУЯ	Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Яам
ДХШХ	Дотоодын Хянан Шалгах Хороо
ЕШ	Ерөнхий Шалгалт
ЗГ	Засгийн газар
МУ	Монгол Улс
МҮИС	Монголын Үндэсний Их Сургууль
МЧХ	Мэдлэг, чадвар, хандлага
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ОУ	Олон Улсын
ОУУБИС	Олон Улсын Улаанбаатар Их Сургууль
ОХУ	Оросын Холбооны Улс
ӨЭМТ	Өрхийн Эрүүл Мэндийн Төв
СЭМҮТ	Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв
УАУ	Уламжлалт Анагаах Ухаан
УМС	Удирдлага Мэдээллийн Систем
УНТЭ	Улсын Нэгдүгээр Төв Эмнэлэг
УЕГ	Улсын Ерөнхий Газар
ХНХЯ	Хөдөлмөр Нийгэм Хамгааллын Яам
ХСҮТ	Хавдар Судлалын Үндэсний Төв
ЧД	Чингэлтэй Дүүрэг
ЧДБ	Чанарын дотоод баталгаажуулалт
ЭМЯ	Эрүүл Мэндийн Яам
ЭХЭМҮТ	Эх Хүүхдийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв
IF	Infact Factor
IUU	International Ulaanbaatar University

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	Олон Улсын Улаанбаатар Их Сургууль International Ulaanbaatar University	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Сувилахуй Nursing	
Индекс	D091301	
Шинжээчид	<p>Ахлагч: Д.Солонго - Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Сувилахуйн сургуулийн Насанд хүрэгчдийн сувилахуйн тэнхимийн ахлах багш, Сувилахуйн ухааны доктор, дэд профессор</p> <p>Гишүүд: Б.Энхтуяа - Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Бизнесийн удирдлага хүмүүнлэгийн сургуулийн профессор, доктор, профессор Б.Оюунцэцэг - Этүгэн их сургуулийн Сувилахуйн сургуулийн захирал</p>	
БМИУЗ-ийн Мэргэжилтэн	Б.Мядагмаа – Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Ажлын албаны магадлан итгэмжлэл хариуцсан шинжээч	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд /Хуваарийг хавсаргав/
	2020.10.10	БМИУЗ-өөс ӨYT-г шинжээчид хүлээн авсан.
	2020.10.20	Шинжээчдийн эхний уулзалтыг зохион байгуулсан.
	2020.10.22-23	Шинжээч сургууль дээр ажилласан
	2020.12.17	Шинжээчид магадлан итгэмжлэлд орж буй сургуульд өөрсдийн тайланг илгээх.
		Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр
	Дээд боловсролын магадлан итгэмжлэх комиссын шийдвэр	
Шалгуур шаардлага /журам/	БМИУЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ы өдрийн 08 тоот тогтоолоор баталсан “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”-ын “Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур шаардлага”	

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Олон Улсын Улаанбаатарын их сургууль нь анх 1995 онд “Улаанбаатар коллеж” нэртэй байгуулагдсан ба 2002 онд “Улаанбаатар дээд сургууль”, 2012 онд “Улаанбаатар их сургууль”, 2015 онд “Олон Улсын Улаанбаатарын их сургууль” болон өргөжсөн байна. Тус сургууль нь нийт 4685 оюутанд үйлчлэх хүчин чадал бүхий 6615м² талбайтай сургуулийн 2 байранд сургалт явуулж байна.

Сувилахуйн тэнхим нь 2007 онд байгуулагдан, “Сувилахуй” хөтөлбөрөөр тасралтгүй 13 жил сургалтын үйл ажиллагаа явуулж, 680 гаруй сувилагч мэргэжилтэнг хөдөлмөрийн зах зээлд бэлтгэн гаргажээ. Уг хөтөлбөрөөр 2007-2014 он хүртэл “Сувилахуйн арга зүйч” D723500, 2014 оноос өнөөг хүртэл БШУ-ны Сайдын А/78 тоот тушаалаар “Сувилахуй” 091301 индекстэй хөтөлбөрөөр сургалт явуулж байна. 2020-2021 оны хичээлийн жилд тус хөтөлбөрөөр нийт 120 оюутан 1-ээс 4-р дамжаанд суралцаж байна.

Монгол Улсын Боловсрол Шинжлэх Ухааны сайдын 2014 оны 04 сарын 28-ны өдрийн А/174 тоот тушаалаар баталсан “Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага”-ын дагуу “Сувилахуй” мэргэжлийн хөтөлбөрийг сүүлийн 5 жилд 3 удаа шинэчлэн сайжруулсан байна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгж нь хөтөлбөрийн зорилгоо “Орчин үеийн сувилахуйн үндэслэгч Флоренс Найтенгелийн сувилахуйн үзлийг үндэс сууриа болгон олон улсын стандартад нийцсэн сувилахуйн тусламж үйлчилгээг үзүүлэх чадвартай сувилагч мэргэжилтнийг бэлтгэхэд оршино” гэж тодорхойлжээ.

Хөтөлбөрийг хэрэгжүүлж буй тэнхим нь үндсэн 7 багш, 1 туслах мэргэжилтэнтэй, үүнээс докторын зэрэгтэй багш 3, үлдсэн нь магистрын зэрэгтэй байна. 2019 оны байдлаар тус тэнхимд профессор 1, дэд профессор 2, багш 4, гэрээт болон зочин профессор 6 ажиллаж байна.

Сүүлийн 5 жилийн байдлаар төгсөгчдийн ажил эрхлэлтийн байдлыг авч үзвэл мэргэжлээрээ ажиллаж байгаа 72 %, мэргэжлийн бус 8 %, мэргэжил, мэдлэгээ дээшлүүлж үргэлжлүүлэн суралцаж байгаа төгсөгч 10 %-тай байна. 2017-2018 оны хичээлийн жилд хийсэн ажил эрхлэлтийн судалгаагаар ажил эрхлэлт 64% байсан бол 2018-2019 оны давтан судалгаагаар 80% болж 16%-иар өссөн үзүүлэлттэй байна. “Сувилахуй” хөтөлбөрийн төгсөгчдийн амжилтаас дурьдвал: гадаадад магистр хамгаалсан 3 (БНСУ-ын Ёнсей ИС, Сөүлийн ИС, БНХАУ-ын ӨМҮИС), Солонгост одоо 1 багш докторантаар суралцаж байгаа ба гадаадад ажиллаж байгаа сувилагч 3 (Солонгос улсад 1, Германд 2) байна.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

- Гадаад, дотоодын их сургуулиудын сувилахуйн хөтөлбөртэй харьцуулсан судалгаа
- Сувилагч мэргэжил нь олон улсад болон Монголд эрэлт ихтэй байгааг нотолсон судалгааны мэдээлэл (ДЭМБ,ЭМЯ, ХНХЯ, www.carercast.com, болон бусад)
- Хөтөлбөрт оролцогч талуудын судалгаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Олон улсын жишиг, ижил төстэй сургуулиудын хөтөлбөрийн харьцуулалт хийхдээ БНСУ-ын туршлагыг илүү тусгасан байна.
- Хөтөлбөр хэрэгжүүлэгч хамт олон нь БНСУ-ын Ча болон Ионсей Их сургуулийн эмнэлэг болон сувилахуйн сургуулиуд, Донгван шинжлэх ухаан, технологийн институт, сувилахуйн сургууль, Бедеста эмнэлэг зэрэг байгууллагуудад туршлага судалж, хөтөлбөрийн баяжуулалт хийсэн байна.
- АШУҮИС, АЧ АУИС, Этүгэн ИС, АНУ ын Нью-Йоркийн ИС-ийн Сувилахуйн сургууль, БНСУ-ын Ионсей ИС-ийн Сувилахуйн сургуулийн хөтөлбөрүүдтэй ижил ба ялгаатай талуудыг харьцуулан судалж, өөрийн хөтөлбөрийн хүрэх үр дүн, өөрчлөлт шинэчлэлтийг хэрхэн сайжруулах боломжтой талаар судалсан нь давуу тал байв.
- “Сувилахуйн үндэс” хичээл заадаг багшийг Ионсей их сургуульд туршлага судлуулж байна.

Анхаарах асуудал:

- Хэдийгээр эрэлт ихтэй мэргэжлийн хөтөлбөр боловч элсэгчдийн тоо харьцангуй бага.

Зөвлөмж:

- Олон улсын болон дотоодын хөтөлбөрүүдтэй өөрийн хөтөлбөрийг харьцуулахдаа агуулга, төгсөгчийн эзэмших мэдлэг, чадвар, хандлагыг авч үзэх нь зүйтэй.
- Оролцогч талуудын санал, нийгмийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан сургалтын хөтөлбөрийн сайжруулалтыг тасралтгүй хийх.

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

- Сувилахуйн мэргэжлийн хөтөлбөр
- Монгол улсад хэрэгжиж буй үндэсний хөтөлбөрүүдтэй нийцэж буй судалгаа
- ОУУБИС-ийн эрхэм зорилго, Сувилахуйн тэнхмийн зорилго, хөтөлбөрийн зорилгын нийцэл
- ОУУБИС-ийн хөгжлийн бодлого, сувилахуйн тэнхимийн стратеги
- Төгсөгчдийн эзэмших мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлохдоо оролцогч талуудын саналыг тусгасан байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Мэргэжлийн индексийн өөрчлөлт, сургуулийн эрхэм зорилго, тэнхимийн зорилго, хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй нийцүүлэн 2014, 2016, 2018 онуудад сувилахуйн хөтөлбөрийн оролцогч талуудын бүрэлдэхүүнийг нэмэгдүүлж, тэдний саналыг тусган, мэргэжлийн хөтөлбөрийг шинэчлэн боловсруулсан. Шинэчлэлт, өөрчлөлтийн үндэслэлийг тодорхой гаргасан.
- Сургалтын хөтөлбөрийг боловсруулах, баталгаажуулах, хэрэгжүүлэх үйл явц, гарах үр дүнг хянах, үнэлэх, чанарыг баталгаажуулах, бодлого эрх зүйн зохицуулалтыг хариуцсан "Хөтөлбөрийн хороо", багууд ажилладаг.
- Эрүүл мэндийн болон боловсролын салбарын хөгжил, өөрчлөлт шинэчлэлттэй холбоотой сургалт семинарт багш нарыг тогтмол оролцуулдаг.
- Ажил олгогчдоос төгсөгчдийн мэдлэг, чадвар, хандлагын судалгааг хийж, хөтөлбөрийн хүрэх үр дүнд нийцэж буйд хөндлөнгийн үнэлгээ хийлгүүлдэг байна. 2017-2019 онуудад ажил олгогчдоос үл нийцлийн судалгаагаар бүрэн нийцдэг 12.8%, ихэвчлэн нийцдэг 75.6% байгаа нь төгсөгчдийн мэдлэг, чадвар, хандлага нь нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцэж байна.
- Хөтөлбөрийн хүрэх үр дүнг 2018 оны сургалтын хөтөлбөрт мэргэжлийн суурь, мэргэжлийн хичээлүүдийн агуулгыг шинэчлэн боловсруулж мэдлэг, ур чадвар, хандлагыг кодоор тодорхойлж гаргасан байна. АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулийн цогц чадамж, ЭМС-ын 102 тоот тушаалаар батлагдсан СУВИЛАГЧ мэргэжлээр төгсөгчдөд тавигдах шаардлагыг удиртгал болгон, мэдлэг **K-24**, ур чадвар **S-4**, хандлага **A-7** шинээр тус тус тодорхойлж хөтөлбөрийн дэд хороогоор хэлэлцүүлсэн байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн хүрэх үр дүн, мэдлэг, чадвар хандлагыг тодорхойлохдоо зөөлөн ур чадваруудыг (Soft skills) төдийлөн сайн тодорхойлж чадаагүй байна.
- Элсэлт бага байгааг цаашид анхаарах нь зүйтэй.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн хүрэх үр дүн, мэдлэг, ур чадвар, хандлагыг тодорхойлохдоо нийгмийн эрэлт хэрэгцээ болон зөөлөн ур чадвар, хувь хүний EQ-ийн чадваруудыг харгалзан үзэх.

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Мэргэжлийн хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө
- Хичээлүүдийн хөтөлбөр
- Хүрэх үр дүн, матриц, хичээлүүдийн залгамж холбоо
- Сургалтын журам
- Хөтөлбөрийн хорооны журам

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**Онцлог зүйл/Давуу тал :**

- Мэргэжлийн хөтөлбөр, сургалтын төлөвлөгөөг Дээд боловсролын тухай хууль болон бодлогын баримт бичигт тулгуурлан 2014, 2016, 2018 онуудад өөрчлөлт шинэчлэлт хийсэн байна. Тухайлбал: агуулга, багц цаг, нэршил, онол дадлагын харьцаа зэрэгт өөрчлөлт оруулсан байна.
- 2018 онд шинэчилсэн мэргэжлийн хөтөлбөрт хүрэх үр дүнг цогц байдлаар гаргасан байна.
- Сургалтын төлөвлөгөөний багц цагт ерөнхий эрдмийн хичээл 29%, Мэргэжлийн суурь хичээл 23,4%, Мэргэжлийн хичээл 42.7%, дадлага 4.8% эзэлж байгаа нь БШУС-ын А/174-р тушаал, бакалаврын сургалтын хөтөлбөрийн "нийтлэг шаардлага"-ыг хангаж байна.
- Хичээлийн хөтөлбөрүүд нь сургалтын хөтөлбөрийн үр дүн, агуулгатай мэдлэг, чадвар, хандлагын матриц хийгдэж, хичээл хоорондын залгамж холбоог гаргасан байна
- Сургалтын арга зүй болон үнэлгээний олон талт аргуудыг ашиглаж оюутан төвтэй үр дүнд суурилсан аргад шилжүүлснээр багаар ажиллах, мэдлэгээ хуваалцах, гардан үйлдэлд сурах, бие даах чадвар сайжирсан, оюутны идэвх нэмэгдсэн байна.

Анхаарах асуудал:

- “Хамт олны сувилахуй” хичээлийн агуулгад халдварт өвчин орсныг салгаж, “Халдварт өвчний сувилахуй” хичээлийг заавал судлах хэсэгт нэмж оруулах.
- УАУ хичээлийг сонгон судлах хичээлээс заавал судлах хэсэгт оруулах.
- Сургалтын төлөвлөгөөнд чөлөөт сонголтын хичээлийг нэмэх.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийг тасралтгүй сайжруулах.
- Ижил төстэй сургуулиудаас ялгарах онцлогийг тодорхойлж, олон нийтэд түгээж, элсэлтийг сайжруулах.

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

- УМС-д хичээл, багш сонголт, хуваарь, дүнгийн мэдээлэл
- Дадлагын бааз эмнэлэгт хамтран ажиллах гэрээ
- Дадлагын удирдамжуудыг нэгтгэсэн гарын авлага
- Хөтөлбөрийн хүрэх үр дүн, хөтөлбөрийн зорилго, зорилт, агуулга нийцэл хийсэн судалгаа
- Ижил төстэй сургалт явуулдаг сургуулиудтай хэрэгжүүлэх буй хөтөлбөр
- Хичээл хэлбэр, онол дадлагын харьцаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл:

- 2016-2018 оны хичээлийн жилүүдэд дадлагын хичээлийн агуулга үр дүнтэй нийцсэн байдал, хичээлийн үр дүнгийн сэтгэл ханамж, сургуулийн давуу болон сул тал зэрэг асуудлаар судалгаа хийхэд оюутнууд сэтгэл ханамжтай гэсэн үнэлгээ өгсөн байна.
- Сувилахуйн хөтөлбөрт лекц 54%, семинар 23%, дадлага 23% байна.
- Сувилахуйн мэргэжлийн оюутнууд нь сургуулийн давуу талыг хамгийн их сургалтын тэтгэлэг олгодог, бүх оюутнуудад англи, солонгос хэлийг заавал судлах хичээлд оруулан заадаг гэсэн үзүүлэлтүүдийг чухал гэж үзсэн байна.

- Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтанд сүүлийн 4 жилийн дунджаар 90%-ээс дээш хувьтай шалгагддаг нь төгсөгчид мэргэжлээрээ ажиллах боломж бүрддэг байна.
- АШУҮИС, Чусоны ИС, МҮИС, ДЭМБ, ЭМЯ-тай хамтарсан сувилагч бэлтгэх хөтөлбөрийн шинэчлэл, Сувилахуйн талаар баримтлах бодлого, идэвхтэй сургалтыг арга, Сувилахуйн удирдлага манлайлал зэрэг сургалт, семинар зохион байгуулсан байна.
- Дадлагын бааз эмнэлэгтэй нягт хамтран ажиллаж, танхимаар сурсан мэдлэг чадвараа практикаар дадлагажих боломжийг бүрдүүлж, "Эмнэлгийн дадлагын нэгдсэн удирдамж" боловсруулсан нь оюутнуудад эмнэлэг дээр дадлага хийхэд юу сурч мэдэх, хэрхэн үнэлгээ авах зэрэг нь тодорхой болсон байна.
- Төгсөгчид нь БНСУ-ын сувилахуйн лицензийн шалгалт өгөх эрхтэй, мөн магистрт төлбөргүй суралцах боломжтой.
- БНСУ-ын Сувилахуйн сургууль, эмнэлэгт 70 гаруй оюутан урт, богино хугацаагаар дадлагажсан нь маш үр дүнтэй болсон байна. Мөн Солонгос улсын ижил төстэй их сургуулийн 90 гаруй оюутнуудыг Сувилахуйн тэнхим хүлээн авсан байна.
- Мэргэшүүлэх хичээлүүдийг АНУ, Солонгосын зочин профессоруудыг урьж оруулдаг, мөн багш нараа гадаад дотоодын сургалтанд байнга оролцуулдаг байна.
- Сувилахуйн хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, чадвар, хандлагыг кодоор гаргаж, хичээлүүдтэй матриц хийж хэрхэн нийцэж буйг тодорхойлсон байна.
- Багш нар нь үндэсний хэмжээний хөтөлбөр, сурах бичгийг хамтран боловсруулахад идэвхитэй оролцдог байна.
- Оюутнууд <http://info.ubu.mn> хаягаар хичээл, багш сонголт, хуваарь, шалгалтын дүн, суралцах хугацаанд судалсан бүх хичээлийн кредит, дүн, голч дүнг харах, өөрийн хувийн мэдээллийг өөрчлөх шинэчлэх боломжтой.
- Багш нар Prof.ubu.mn хаягаар өөрийн заах хичээлийг сонгосон оюутнуудын нэрсийг харах, хэвлэж авах, дүн оруулах, сурлагын амжилт чанарын үзүүлэлтийг авах, оюутнуудын мэдээллийг харах боломжтой.
- Сувилахуйн хөтөлбөрийн хичээл нь лекц, семинар, дадлага хэлбэрээр онол, бие даалт, эссэ бичих, кейс дээр ажиллах, сэтгэн бодож шийдвэр гаргах зэргээр бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх чадвар олгогдоход чиглэгдсэн байна.
- Сургалтын албанд E-контент хариуцсан нэгжтэй, багш нар хичээлээ цахим болгох, гадаадын нэр хүндтэй сургуулиудын цахим сургалтын материалыг оюутнуудад хүргэх, цахим тестийн сан, блог хөтлөх зэргээр ажиллаж, олон ажлыг төлөвлөсөн байна.

Анхаарах зүйл:

- Нэг багш 3-5 төрлийн хичээл заадаг нь их сургуулийн багш 3-аас илүү төрлийн хичээл заахгүй гэснийг зөрчиж байна. (БСШУ сайдын 2010 оны 26 тоот тушаал Дээд боловсролын сургалтын байгууллагын ангилал тогтоох журам)
- Оюутны танхимд симуляц хийх, ажиллах боломж, цагийг нэмэгдүүлэх

Зөвлөмж:

- Үр дүнд суурилсан сургалтын хөтөлбөрийг тасралтгүй сайжруулах.
- Удирдлага мэдээллийн нэгдсэн системтэй болох, оюутнууд онлайнаар суралцах боломжийг бүрдүүлэх.

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- Мэргэжлийн хөтөлбөрийн арга зүй
- Сургалтын төлөвлөгөө, хичээл хоорондын уялдаа, идэвхтэй сургалтын арга зүйн матриц
- Онлайн сургалтын болон e контент хариуцсан нэгж
- Оюутны сэтгэл ханамжийн дүн

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Үр дүнд суурилсан аргад тулгуурлан хичээл бүрийн арга зүйг тодорхойлсон. Орчин, туршилт, нөхцөлд суурилсан аргуудыг түлхүү ашигладаг.
- Оюутны тоо цөөн тул идэвхтэй сургалтын аргуудыг ашиглаж боломж бүрдсэн.
- Хэрэглээний болон SPSS судалгааны программыг ашиглан судалгааны арга зүй, сувилахуйн судалгаа, НЭМ хичээл дээр судалгааны анхан шатны боловсруулалт, анализ хийдэг байна.
- Жил бүр оюутнуудын сэтгэл ханамжийн судалгаа авч, үр дүнг тооцож тайлан гаргаж хөтөлбөрийг сайжруулахад ашигладаг байна.

Анхаарах асуудал:

- Дэвшилтэт технологи ашигласан арга зүйг цаашид сайжруулах

Зөвлөмж:

- Сургалтанд виртуал лаборатори, case application, аудио, видео, подкаст, аудиовизуал тест зэрэг дэвшилтэт аргуудыг ашиглах

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Оюутныг үнэлэх болон төгсөлтийн журам, үнэлгээний систем
- Хичээлийн хөтөлбөр дэх үнэлгээний арга
- prof. ubu .mn программ
- Хөтөлбөрөөр суралцагчдын сурлагын амжилтын ахицын мэдээлэл

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Суралцагчдын мэдлэг, чадвар, хандлагыг БСШУ-ны сайдын 158 тоот тушаалыг баримтлан элсэлт, явц, улирал, дадлага, төгсөлт, хөндлөнгийн үнэлгээгээр үнэлдэг байна.
- Сувилахуйн хөтөлбөрт үнэлгээний 13 арга батлагдсанаар суралцагчдыг бодитой, шударга, ижил үнэлэх боломж бүрдсэн.
- Суралцагчдын сурлагын амжилт чанарын судалгааг улирал бүрийн эцэст хийдэг ба оюутнуудын дундаж дүн В үнэлгээтэй байна.

Анхаарах асуудал:

- Оюутнуудын сурлагын амжилт, чанарын судалгааг тасралтгүй сайжруулах

Зөвлөмж:

- Оюутнуудын сурлагын амжилт ахицын талаар судалгаа гаргахдаа хүрэх үр дүн, дэмжиж буй МЧХ-тай харьцуулж гаргаж, хөтөлбөрийн сайжруулалтанд ашиглах
- Хичээл бүрийн үнэлгээний аргыг илүү тодорхой болгох, зөөлөн ур чадварыг (Soft skill) үнэлэх
- E контент бэлтгэн ашиглах
- Сурлагын амжилт, чанарыг багшийн заах арга зүй, сургалтын хэрэглэгдэхүүн, ном сурах бичгийн хүрэлцээ хангамж зэрэгтэй харьцуулах боломжтой.

Шаардлага:

- Оюутны сургалтын үнэлгээг хөтөлбөрт бодитой (мэдлэг, чадвар, хандлагатай нь харьцуулах) тусгаж оруулах шаардлагатай.

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

- Хичээлийн болон оюутны дотуур байр бүхий цогцолбор
- 2 га бүхий эдлэн газар
- 4200 м² бүхий 45 анги танхим
- 1681м² бүхий 27 лаборатори
- Спортын их бага заал, лабораториуд
- 24 цагийн харуул хамгаалалт, камержуулалт, гэрэлтүүлэг
- Интернет орчин
- Дадлагын бааз
- Сувилахуйн мэргэжлийн 6 лабораторийн өрөө
- Сувилахуйн мэргэжлээр суралцагчдын сэтгэл ханамжийн судалгаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- ОУУБИС-ын хэмжээнд сүүлийн 5 жилд 63.1 сая төгрөгийг засвар, тохижилтонд зарцуулсан байна.
- Дээд боловсролын байгууллагад тавигддаг нийтлэг шаардлага, стандартыг хангасан анги танхим, лаборатори, спорт зал, номын сан, багш, оюутны дотуур байр, интернэт болон чөлөөт цагаа өнгөрөөх төв, өдөр өнжүүлэх өрөө /оюутнууд хүүхдээ өгөх боломжтой/, багш оюутны хоолны газар, кофе шоп, хурлын болон урлагийн заал
- Бүрэн дунд сургууль, цэцэрлэг, өдөр өнжүүлэх
- Оюутанд ноогдох талбай 1.1-2.1 м/кв
- Интернет орчин, олон нийтийн сүлжээ ашиглах, компьютерийн боломж хүрэлцээ хангамж, сайн гэж судалгаагаар нотлогдсон.
- ОУУБИС нь 2015 онд “Хувийн их дээд сургуулийн консерциум”-аас “шилдэг дотоод орчинтой сургууль”-иар шалгарсан.
- Виртуал, дижитал орчин бүхий E контент бэлтгэх тоноглогдсон өрөөтэй.
- Хангамж үйлчилгээний хэлтэс нь эрүүл, аюулгүй, тохилог орчинг бүрдүүлэхэд чиглэсэн стратеги төлөвлөгөөний дагуу ажилладаг.
- Гэр бүлд зөвөлгөө өгөх төв, өндөр хурдны интернэт бүхий “Интернэт плаза”, WI FI бүхий нийтийн эзэмшлийн коридор, амралтын хэсгүүдтэй.
- Гоц халдварын үед ашиглах тусгаарлах өрөө бэлтгэсэн.
- Судалгаагаар сувилахуйн мэргэжлийн оюутнуудад нь ОУУБИС-д суралцаж байгаадаа 83% нь сэтгэл хангалуун, 17% нь заримдаа сэтгэл хангалуун гэж үзсэн байна.

Анхаарах асуудал:

- Төгсөгчид болон суралцагсадтай хийсэн ярилцлагын дүнгээс үзэхэд: сургалтын бааз болох эмнэлэгт, 2-3 эмнэлгээс бусдад нь оюутны хувцас солих локер байдаггүйгээс оюутнууд коридорт хувцсаа сольдог байдлыг анхаарч, ажил олгогч болон эмнэлэгүүдтэй байгуулсан хамтран ажиллах гэрээнд нэмж тусгах шаардлагатай.

Зөвлөмж:

- Сургуулийн удирдлагын зүгээс оюутны суралцах таатай орчинг бүрдүүлэн, эмнэлгийн дадлагын сургалтанд зориулж, хувцас солих локероор хангаж өгөх боломжийг судлах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Дотоод сүлжээ VLAN, аюулгүй байдлын сервер
- Номын сан - LIB4u1.9
- Санхүүгийн - Vinnica
- Эрдэм шинжилгээний Research .ubu.mn програмууд
- Сургалтын техник хэрэгслийн судалгаа
- Мэргэжлийн суурь болон мэргэшүүлэх хичээлүүдийн лабораториудын ашиглалтын болон хэрэглэгдэхүүний судалгаа
- Эмнэлгийн нэгдсэн дадлагын удирдамж

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Интернет орчин сайтай, судалгааны лицензтэй програмуудтай.
- Сувилахуйн хөтөлбөрт шууд хамааралтай тоноглогдсон 1 лекцийн заал, 4 анги, морфологи, эх хүүхдийн сувилахуй, сувилахуйн үндэс, эрүүл мэндийн үнэлгээ, химийн лаборатори, бие даан суралцах төвүүд.
- 2020-2027 оны хугацаанд эх хүүхдийн лабораторт шаардлагатай 138 сая төгрөгийн техник хэрэгсэл авахаар төлөвлөсөн байна.
- Дотоод сүлжээндээ Opticalcable-ийн ашиглан ISO стандартын CISCO төхөөрөмжүүдээр орчин бүрдүүлж аюулгүй байдлыг ханган ажилладаг.
- 2019-2023 онд дижитал номын сан хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлэхээр ажиллаж байна.
- 2015-2016 онд СЭЗИС-ийн номын сангаар дамжуулан олон улсын эрдэм шинжилгээ, судалгааны мэдээллийн сан болох EBSCO-г ашиглах эрх авсан.

- Сургалтанд ашиглах тараах материал, тест, дадлагын удирдамжийг оюутнуудад хүртээмжтэй байлгахад анхаарч хувилж, хэвлэж өгдөг.
- Номын санг LIB4U NET Version програм ашигладаг ба электрон каталоги 23305 төрлийн 51178 ширхэг ном, 800 гаруй е номын баазтай.

Анхаарах асуудал:

- Сувилахуйн мэргэжлийн хичээлүүдийн гардан үйлдлийн зориулалтын хэрэглэгдэхүүний төрөл зүйл цөөн, хуучирсан (2014 оноос хойш шинэчлэгдээгүй).
- Сувилахуйн мэргэшүүлэх ур чадварын өрөөнд /лаборатори/ эмнэлгийн орчинг бүрдүүлээгүй.

Зөвлөмж:

- Сувилахуйн гардан үйлдлийн ур чадварын /лаборатори/ эмнэлгийн нөхцөлд ойртуулж, халдвар хамгааллын дэглэмийг сахиснаар оюутанд мэргэжлийн соёл төлөвшүүлэх, тэдэнд туслах боломжийг бүрдүүлдэг сайн талтайг анхаарах

Шаардлага:

- Сувилахуйн гардан үйлдлийн ур чадварын өрөөнд эмнэлгийн орчин бүрдүүлэн, халдвар хамгааллын дэглэм баримтлан ажиллах шаардлагатай.
- Зарим гардан ажилбарын хэрэглэгдэхүүнийг /тарилгын муляж, CPR-ын муляж г.м/ шинэчлэн, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангаж ажиллах шаардлагатай.

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Ном сурах бичгийн хүртээмжийн болон ашиглалтын судалгаа
- Номын санчийн оронд бүрдүүлэлт хийх журам
- Номын шинэчлэлт баяжуулалтын судалгаа
- Цахим ном сэтгүүл
- Электрон каталог бүхий номын сангийн цогц программ
- Дижитал сургалтын материалууд

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сувилахуйн хөтөлбөрт хамааралтай ерөнхий суурь хичээлийн 7797, мэргэжлийн суурь хичээлийн 557, мэргэжлийн 841, цахим 26, эрдэм шинжилгээний сэтгүүл 194, мэргэжлийн сэтгүүл 89, гадаад хэл дээрх

1576 ширхэг ном сурах бичгийг 12501 удаагийн давтамжтай ашигладаг байна.

- Үндсэн багш нарын гаргасан болон орчуулсан мэргэжлийн сурах бичиг, гарын авлага тодорхой хувийг эзэлдэг ба "Эхийн сувилахуй 1, 2", "Хүүхдийн сувилахуй 1, 2", "Хамт олны сувилахуй 1, 2" зэрэг 10 төрлийн мэргэшүүлэх хичээлийн клиник дадлагын удирдамжийг боловсруулсан.
- Зохиогчийн эрх нь шилэгдсэн бүтээлүүдийг цахимд шилжүүлсэн (Англи, Монгол, Солонгос хэл дээр).
- Харааны бэрхшээлтэй суралцагчдад зориулсан төхөөрөмжтэй.
- 2014 оноос хойш 6 сая гаруй төгрөгийн үнэ бүхий 52 төрлийн 178 мэргэжлийн сурах бичиг худалдан авсан.

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- ОУУБИС-ийг 2013-2023 онд хөгжүүлэх стратеги төлөвлөгөө
- Тэнхим, багш нарын жилийн ажлын төлөвлөгөө
- 2020-2021 оны хичээлийн жилийн Оюутны албаны үйл ажиллагааны төлөвлөгөө
- Хөтөлбөрийн хорооны журам
- Сувилахуйн хөтөлбөрийн хорооны бүтэц, үйл ажиллагааны схем
- Хөтөлбөрийн хороо, профессорын баг, тэнхимийн хурлын шийдвэр, тэмдэглэл
- ОУУБИС-ийн веб хуудас

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

Сувилахуйн тэнхим хөтөлбөрийн дэд хорооны чиг үүргийг хэрэгжүүлдэг. 2015 онд Хөтөлбөрийн дэд хороо байгуулагдсан ба энэ хугацаанд хорооны журам 2, хорооны бүрэлдэхүүн 6 удаа өөрчлөгдсөн.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд БСШУ-ны сайдын 2014 оны А/78, А/174, А/285, 2017 оны А/52 тушаал болон ОУУБИС-ийн захирлын, Эрдмийн зөвлөлийн,

Хөтөлбөрийн ерөнхий хорооны 2014-2018 онд гаргасан 5 тушаал, 1 тогтоол, 1 хурлын протокол, Сувилахуйн тэнхимийн/хөтөлбөрийн дэд хорооны 2015-2019 оны 25 удаагийн хурлын протокол бүхий нийт 32 баримт нотолгоо бүрдүүлсэн нь Хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх дүрэм, журам түүний хэрэгжилт хангалттай болохыг харуулж байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч тэнхим/хөтөлбөрийн дэд хороо нь сургалтын чанарыг сайжруулах зорилгоор багш нар, оюутан, төгсөгч, ажил олгогч, эцэг эхээс сэтгэл ханамжийн судалгааг авдаг.

ОУУБИС-ийг 2013-2023 онд хөгжүүлэх стратеги төлөвлөгөө харьцангуй сайн боловсрогдсон. 2013-2023 онд хөгжүүлэх стратеги төлөвлөгөөнд 5 тэргүүлэх чиглэл/зорилго тодорхойлж, хэрэгжүүлэх үе шатыг 2013-2014, 2015-2018, 2019-2023 онуудаар төлөвлөсөн. Сувилахуй тэнхим болон багш нар жил бүр сургалт, эрдэм шинжилгээ, нийгмийн ажил гэсэн 3 хэсэг бүхий төлөвлөгөө боловсруулж, тайлан гаргадаг. Сургуулийн тайлан, төлөвлөгөөний хэрэгжилтэд ДХШХорооны ажилтан дүн шинжилгээ хийж тайлагнаж ирсэн.

Сувилахуйн хөтөлбөрийн суралцагчдаас ирсэн өргөдөл нь оюутны шилжилт хөдөлгөөнтэй холбоотой ба түүнийг шийдвэрлэн ажилладаг байна. 2014 оноос эхлэн улирал бүр оюутнуудаас багш, хичээл, хөтөлбөрийн талаар сэтгэл ханамжийн судалгааг авдаг болсон.

Анхаарах асуудал:

- Багш нарын болон тэнхимийн төлөвлөгөө, сургуулийн стратеги төлөвлөгөө, тайлангууд хоорондоо холбоогүй, үзүүлэлтүүд нь зөрүүтэй, хэмжигдэхүйц бус.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой эрхзүйн баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ байхгүй.
- Хөтөлбөрт ирсэн санал гомдол, шийдвэрлэсэн байдал нь зөвхөн оюутны шилжилт хөдөлгөөнтэй холбоотой.
- Сургалтын удирдлага, мэдээллийн системийн ашиглалт, хяналт, ил тод байдалд хийсэн дүн шинжилгээний үр дүн батлагдахгүй.

Зөвлөмж:

- Багш нар болон тэнхимийн төлөвлөгөө, сургуулийн стратеги төлөвлөгөөний уялдаа холбоог сайжруулах, үзүүлэлтүүдийн зөрүүтэй байдлыг арилгах.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой эрхзүйн баримт бичгийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж хэвших.
- Сургуулийн стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд дүн шинжилгээ хийхэд ДХШХороо, ажилтаны үүрэг оролцоог нэмэгдүүлэх.
- Хөтөлбөрт ирсэн санал гомдол, хэрхэн шийдвэрлэсэн байдлын судалгааг хийж хэвших, хөтөлбөрийн чанарыг сайжруулахад тусгах.
- Сургалтын удирдлага, мэдээллийн системийн ашиглалт, хяналт, ил тод байдалд дүн шинжилгээг хийдэг болох.

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш,

суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Хамтран ажиллах гэрээ, санамж бичгүүд
- Мэргэжлийн холбоодтой хамтран ажилласан ажлын тайлан, 2008-2020 он
- Төгсөгчдийг магистр, докторт сургах бодлого төлөвлөгөө
- ОУУБИС-ийн өрсөлдөх чадварын судалгаа, 2018 он
- Төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгаа, 2019-2020 он
- Ажил олгогчийн сэтгэл ханамжийн судалгааны тайлан, 2019-2020 он
- Оюутны сэтгэл ханамжийн судалгаа, түүний үр дүн, тооцоолол, 2017 он

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- ОУУБИС нь БНСУ-ын сувилахуйн 5 их дээд сургууль, 2 эмнэлэг, ОХУ-Дорнод сибирийн удирдлага, технологийн их сургууль, дотоодын 3 их сургууль (Этүгэн, АШУҮИС, МҮИС), 14 эмнэлэг (3-р эмнэлэг, ЭХЭМҮТөв, СЭМҮТ, Интермед, БЗД, БГД-ийн ЭМТ, Бичил мандал, Мэлмий хурц, Манай эмнэлэг, Шар дэгд ӨЭМТ, УНТЭ, ХСҮТ, УТ 2-р эмнэлэг, Бриланс клиник ХХК), Монгол сувилахуйн нийгэмлэг, Эрүүл мэндийн хөгжлийн төвтэй хамтран ажилладаг. Улсын 3-р эмнэлэг, ЭНЭМҮТ эмнэлэг болон дотоодын 3 их сургуультай хамтран ажилласан ажлын үр дүн, тайлан гаргасан, үр дүн сайн.
- Тэнхим дотоодын хамтран ажилладаг эмнэлэг, сургуулиудад оюутнуудыг дадлага хийлгэх, гаргасан ном, гарын авлагаасаа өгдөг, өрөө тасалгаагаар үнэгүй үйлчилдэг ба захиалгаар сургалт явуулдаг, семинар хамтран зохион байгуулдаг. Мөн ой, тэмдэглэлт баяраар нь мөнгөн хандив, урамшуулах үйл ажиллагааг зохион байгуулж ирсэн. Түүнчлэн багш, оюутныг гадаад хамтын ажиллагаатай их дээд сургууль эмнэлэгт танилцах дадлагад хамруулдаг. Өөрийн сургуулийн төгсөгчдийг давтан магистрын сургалтанд хамруулах бодлоготой, хэрэгжүүлэх хэлтэстэй, төлөвлөгөөтэй. Энэ ажлын хүрээнд 10-20 хувийн хөнгөлөлттэй сургадаг, 400.0-500.0 мянган төгрөгийн тэтгэлэг олгодог.
- Багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдагсдын тоон судалгааг гаргадаг.
- Багш, суралцагчдын зүгээс нийгэмд, мэргэжлийн байгууллага ажиллагсад чиглэсэн сургалт, семинарыг зохион байгуулдаг.

Анхаарах асуудал:

- Олон улсын хамтарсан төсөл хэрэгжүүлж байсан туршлагатай боловч бага, /3 багш оролцсон/ багш нарын оролцоо жигд бус. Их сургууль боловч түүнд тавигдах шаардлагын дагуу сургуулийн дотоод захилгат, санхүүжилт бүхий төсөл хэрэгждэггүй.
- Хамтарсан хөтөлбөр одоогоор байхгүй.

- Төгсөгчдийг академик бус давтан сургалтад төлөвлөгөөтэй хамруулдаг эсэх нь тодорхой бус.
- Багш, суралцагч солилцоо, тэтгэлэг, төсөл хөтөлбөр, хурал семинарт хамрагдагсдын тоонд давхардал их, төлөвлөж, төсөвт тусгаж хэвшээгүй.
- Дотоод, олон улсын хурал, семинар, судалгаа болон арга хэмжээнд багш, оюутнууд оролцсоор Сувилахуйн хөтөлбөр хэрхэн сайжирч байгааг хэмжих боломжгүй.

Зөвлөмж:

- Дотоод, олон улсын хурал, семинар, судалгаа болон арга хэмжээнд багш, оюутнууд оролцсоны үр дүнд Сувилахуйн хөтөлбөр хэрхэн сайжирч байгааг тодорхой үзүүлэлтээр үнэлэх, дүгнэх боломжийг эрэлхийлэх (шалгуур үзүүлэлт, арга зүй).
- Хамтарсан төслийг нэмэгдүүлэх, хамтарсан хөтөлбөртэй болох боломжийг судлах.
- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааг сайжруулах, сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авч хэвших.
- Төгсөгчдөд чиглэсэн сургалтын эрэлт, хэрэгцээг судлах, богино хугацааны сургалт зохион байгуулах боломжоо тодорхойлох.

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- Сургуулийн нэгдсэн орлого, зарлагын судалгаа, 2014-2019 он
- Нэг оюутанд ногдох зардалын судалгаа, 2014-2019 он
- Сувилахуйн хөтөлбөрийн сургалтын орлогын судалгаа, курсээр, 2014-2019 он
- Оюутны арга хэмжээнд зарцуулсан төсөв, 2014-2019 он
- Сувилахуйн тэнхмийн оюутнуудын тэтгэлэгт хамрагдсан байдал, 2016-2020 он

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- ОУУБИС нэгдсэн төсөвтэй, санхүүгийн эх үүсвэр нь оюутны төлбөр, бусад орлогоос бүрддэг. Сургуулийн нийт орлогод бусад орлогын эзлэх хувь сүүлийн 5 жилийн дунджаар 4 орчим хувь. Хөтөлбөр санхүүгийн хувьд нэгдсэн төсвөөс хараат, шаардлагатай санхүүжилтийг тухай бүр хүсэлт гаргаж шийдвэрлүүлдэг.
- Нэг оюутанд ногдох зардал сургуулийн хэмжээнд мэргэжлээс үл хамааран дунджаар тодорхойлогддог. Орлого нь элсэгч, суралцагсдын тооноос хамааралтай. 2014 оноос хойш Сувилахуйн хөтөлбөрөөр суралцагсдын тоо буурсан ч тодорхой хэмжээнд ашигтай ажилласан.

Жилийн эцэст гарсан нийт зардлаа нийт оюутны тоонд хувааж сургалтын төлбөрөөс хөтөлбөрт зарцуулагдсан хувь хэмжээг тодорхойлдог.

- Хөтөлбөрийг үр дүнд хүргэхэд чиглэсэн шинэчлэл, өөрчлөлтөд зориулсан төсөв нь үйлдвэрлэлийн дадлага, оюутны арга хэмжээнд зарцуулсан төсвөөр тайлагнагддаг.
- Төр, хувийн хэвшлийн санхүүгийн дэмжлэг нь Боловсролын зээлийн сан, гадны байгууллагын тэтгэлэгээс бүрддэг. Судалгаагаар боловсролын зээлд хамрагдах оюутны тоо буурсан бол тэтгэлэгт хамрагдах оюутны тоо өссөн. Тэтгэлэгт хамрагдах шалгуурыг хангасан оюутан хэдэн ч тэтгэлэгт хамрагдах боломжтой.
- 2017-2018 оны хичээлийн жилд санхүүгийн нэмэлт эх үүсвэрийг хадгаламжийн хүүний орлогоор нэмэгдүүлсэн.
- 2020-2021 оны хичээлийн жилийн төсвийн төлөвлөлт нь өмнөх жилүүдтэй харьцуулахад орлого, зардалын ангилал илүү ойлгомжтой, тодорхой буюу төсвийн төсөөлөл өөдрөг төлөвтэй томъёологдсон.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайланд санхүүгийн үзүүлэлт ойлгомжгүй, санхүүгийн тайлангаас зөрүүтэй, алдаатай бичигдсэн. Мөн Хүснэгт 4.18-д шууд болон шууд бус зардалууд холилдож хэт ерөнхий байдлаар бичигдсэн байгааг анхаарах.
- Сувилахуйн хөтөлбөр хэрэгжүүлж буй зарим их дээд сургуулиудад сургалтын төлбөрийг 100 хувь чөлөөлөх, үнэгүй сургах бодлого баримталж байна. Сувилахуйн мэргэжил зах зээлд эрэлттэй байхад тус сургуулийн элсэгчдийн тоо сүүлийн жилүүдэд буурч байгаа нь уг хөтөлбөрийг тасралтгүй тогтвортой явуулах санхүүжилт, эх үүсвэрт нөлөөтэй ба цаашид элсэлтийн ямар бодлого баримтлах, санхүүжилтийн эх үүсвэрийг баталгаатай болгохоос ихээхэн хамаарах болж байна.
- Хөтөлбөрийн үр дүнг сайжруулах, шинэчлэх, өөрчлөхөд зориулсан төсвийг хөтөлбөрийн нэгжийн санал, төлөвлөгөө, сургуулийн стратеги төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөж, хэрэгжүүлж хэвших. (Сургалтын дадлагын хэрэглэгдэхүүнд 2014 оноос хойш хөрөнгө оруулалт хийгээгүй)
- Төсвийн уламжлалт бус олон эх үүсвэрийг бий болгох, бүрдүүлэлтэд онцгой анхаарах

Зөвлөмж:

- Өөрийн үнэлгээний тайланд санхүүгийн тоон мэдээг ойлгомжтой, тодорхой, зөрүүгүй, алдаагүй болгон засвар оруулах.
- Олон улс, улсын хэмжээнд бүхэлд нь хамарсан эдийн засгийн мөчлөгийн үед богино, дунд хугацаанд авч хэрэгжүүлэх “Санхүү, төсвийн нөөц төлөвлөгөө”-тэй болох.
- Гадны байгуулагаас орж ирсэн тусламж, санхүүгийн дэмжлэгийн зарцуулалтыг илүү тодорхой болгох, тайлагнах, хяналтын тогтолцоог бүрдүүлэх.

- Төсвийн уламжлалт бус эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломжийг судлах, хэрэгжүүлэх.

Шаардлага:

- Сувилахуйн (болон бусад мэргэжлийн хувьд ч адил) мэргэжлийн онцлог, сургалтын хэрэгцээнд суурилан нэг оюутанд ногдох өртөг, зардлыг бодитой тооцдог болох шаардлагатай.
- ОУУБИС-ийн бодлогын баримт бичигт тодорхойлсон төсвийн 10 хувийг төсөл, хөтөлбөрт зарцуулах бодлогоо хэрэгжүүлэх.

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- IUU PODCAST#20, #6 Youtube
- Instagram.com /iuuniversity/
- Ulaanbaatar.edu.mn
- ОУУБИС-ийн өрсөлдөх чадварын судалгаа, 2018 он
- Төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгаа, 2019-2020 он
- Ажил олгогчийн сэтгэл ханамжийн судалгааны тайлан, 2019-2020 он

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөдөлмөрийн зах зээлийн тандан судалгааг төгсөгч болон, ажил олгогчоос авдаг байна. Төгсөгчдийн хувьд ажил эрхлэлт болон сэтгэл ханамжийн судалгааг хийдэг бол ажил олгогчдоос төгсөгчдийн талаар сэтгэл ханамж ямар байгааг асуулгаар тодруулдаг.
- Хөтөлбөрийн сурталчилгаа нь сургуулийн веб хуудас дахь мэдээлэл, тэнхим болон төгсөгчдийн Youtube-д байршуулсан подкаст, Instagram-д байршуулсан зураг, мэргэжил сурталчилах өдөрлөг, тараах материал, бүрэн дунд сургуулийн төгсөх ангийнханд мэргэжил сурталчилах, эрүүл мэндийн боловсрол олгох сургалт зохион байгуулах зэрэг үйл явцаар хийгддэг. Мөн багш, оюутнууд хамтран нийгэмд, мэргэжлийн байгууллага ажиллагсадад чиглэсэн сургалт, семинарыг зохион байгуулдаг.
- Оюутнуудын дунд зохион байгуулагддаг эрдэм шинжилгээний хурал, эссэ бичлэгийн уралдаан, элсэлтийн шалгалтанд бэлтгэх сургалт, төгсөгчдийг мэргэжлийн зөвшөөрлийн шалгалтанд бэлтгэх, төгсөх курсын оюутнуудыг ажлын байранд зуучлах, зөвлөх арга хэлбэрүүдээр идэвхжүүлэлт хийдэг бна.
- Сувилахуйн хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт 4.4-ийн тайлагнал хангалттай бус байсан хэдий ч шинжээчийн баг газар дээр нь очиж ажиллахад хангалттай нотлох баримт олдсон.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн сурталчилгаа, идэвхжүүлэлтийн хүртээмж, үр нөлөөг хэрхэн тодорхойлдог нь тодорхой бус.
- Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц маркетингийн идэвхжүүлэлтийн тухайлсан хөтөлбөр, төлөвлөгөөгүй.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн сурталчилгаа, идэвхжүүлэлтийн хүртээмж, үр нөлөөг тодорхойлох шалгуур үзүүлэлтийг тодорхой болгох.
- Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлтийн тухайлсан хөтөлбөр, төлөвлөгөөг тодорхой үзүүлэлтээр, хэмжигдэхүйц байхаар боловсруулах, шаардлагатай төсөвийг төсөвт тусгадаг байх.

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

- IUU PODCAST#20, #6 Youtube
- Instagram.com /iuuniversity/
- Ulaanbaatar.edu.mn

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээх чиглэлээр сургуулийн албан ёсны Ulaanbaatar.edu.mn нэр бүхий вебсайтыг тогтмол ажиллуулж ирсэн. Уг вебийн бүтэцэд хөтөлбөртэй холбоотой ерөнхий мэдээллүүд хангалттай, тодорхой нарийн мэдээллүүд товч, ерөнхий байдлаар тусгагдсан.
- 2020 оны 9 сарын 29-ны өглөөний байдлаар тус сургуулийн вебсайтын өгөгдлийн бааз дахь бүх мэдээлэл устаж ID, нууц үг нь өөрчлөгдсөн. Энэ тухайгаа өөрийн вебсайт байрлах ЭС ТИ ЭКС СИТИНЕТ компанид хандан сэргээж байгаа ба УЕГ-ын эрүүгийн цагдаагийн албаны кибер гэмт хэрэгтэй тэмцэх газарт 2020 оны 9 сарын 30-д 1/317 тоот албан бичгийг хүргүүлсэн байна.
- Шинжээчдийг очиж ажиллах үед вебсайт ажиллаж байгаагүй.
- Шинжээчийн баг ОУУБИС-ийн Сувилахуйн сургуулийн “Сувилахуй” бакалаврын хөтөлбөрийг 2020 оны 1 сард магадлан итгэмжлэхээр өөрийн үнэлгээний тайланг хүлээн авч ажилласан ба энэ хугацаанд бид тус сургуулийн вебсайтын мэдээлэлтэй хэд хэдэн удаа орж танилцаж байсан болно. Сургуулийн вебсайтад өмнө байсан мэдээллүүд болон

үүссэн нөхцөл байдал, Вейбсайтыг сэргээсэн байдал зэргийг харгалзан уг шалгуурын дүгнэлтийг гаргасан болно.

Анхаарах асуудал:

- 2020 оны 1-9 сарын байдлаар тус сургууль Ulaanbaatar.edu.mn нэр бүхий вебсайтыг тогтмол ажиллуулж ирсэн боловч мэдээллийн иж бүрэн, шинэлэг байдал хангалтгүй. Сувилахуйн хөтөлбөрийн мэдээлэл товч, ерөнхий, хуучин байв.
- 2020 оны 10 сарын байдлаар Вебсайтын мэдээллийн иж бүрэн байдал, тогтмол ажиллагаа алдагдсан буюу хакердуулсан нь хөтөлбөрийн ил тод, нээлттэй байдалд эрсдэл дагуулж байна.
- ОУУБИС нь мэдээллийн аюулгүй байдал, хамгаалалтаа баталгаажуулахад анхаарах.
- Одоогоор Вебсайт ажиллаж эхэлсэн ч мэдээллийн иж бүрэн байдал бүрэн бус. Тухайлбал, Тэнхмүүдийн үйл ажиллагаа, хөтөлбөртэй холбоотой хангалттай мэдээлэл үзэх боломжгүй байна.

Зөвлөмж:

- Мэдээллийн аюулгүй байдал, хамгаалалтыг баталгаажуулах. Үүнд компьютер, мэдээллийн технологийн тэнхмийн мэргэжлийн профессор багш нарын потенциалыг ашиглах.
- Хөтөлбөрийн ил тод, нээлттэй байдлыг сайжруулахын тулд цаг үеийн болон хөтөлбөрийн мэдээллийг тухай бүр оруулах, шинэчилж хэвших

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

Суралцагчийн нийгмийн хэрэгцээ их байгаа ч сүүлийн жилүүдэд элсэгчдийн тоо буурч байна. Элсэлтэнд тавигдах нийтлэг шаардлагыг бүрэн хангасан. Элсэлтийн үйл ажиллагаа нь нээлттэй, ил тод зохион байгуулах боломжийг бүрэн хангасан. Сувилахуйгаар төгсөгчдийн 90% орчим нь ажлын байраар хангагддаг байна.

- БСШУЯ-ны сайдын 2013 оны А/79 тоот “Оюутан элсүүлэх журам”
- БСШУЯ-ын сайдын 2018 оны А/194 тоот “Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” тушаал

- “Босго оноо тогтоох тухай” А/195 тоот тушаалд нийцүүлэн боловсруулсан “Бакалаврын оюутан элсүүлэх журам”-ын дагуу оюутан элсүүлдэг.
- Суралцагч элсүүлэх эрхзүйн зохицуулалт болон журам, элсэлтийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг <http://iuu.edu.mn/> сайтад нээлттэй байршуулж хэвшсэн.
- Сувилагч мэргэжилтнээр элсэгчдэд зориулсан сурталчилгаа, мэргэжил сурталчлах өдөрлөгийг жил бүрийн 5-р сард зохион явуулдаг.
- Жил бүр төгсөгчдийн болон ажил олгогчдын судалгаа авдаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2020 оны хичээлийн жилийн элсэгчдэд сургалтын төлбөрийн хөнгөлөлт үзүүлсэн байна. 2016-2020 хүртэл нийт 147 оюутанд 73.549.150 төг-ийн тэтгэлэг өгсөн байна.
- Сүүлийн 5 жилийн элсэлтийн тоо: /2014-2015 жилд 55, 2015-2016 жилд 37, 2016-2017 жилд 30%, 2017-2018 жилд 51, 2018-2019 жилд 16, 2019-2020 онд 10, 2020 онд 30 оюутан орсон байна./ ЕШ-ийн химийн оноо 410, гадаад хэл болон биологийн хичээлийн үнэлгээг үндэслэсэн байна.

Зөвлөмж:

- Сувилагч мэргэжлээр элсэлтийн бодлого, маркетингийн төлөвлөгөөтэй байх. ЭМЯ, ХНХЯ-ны эрэлт хэрэгцээнд үндэслэх.
- Элсэлтийн шалгалтанд ярилцлагын шалгалтыг оруулах талаар судлах /мэргэжлийн онцлогоос шалтгаалж, харилцаа хандлага, мэргэжлийн сонирхол, гадаадын орны туршлага/.
- Сувилахуйн ангид хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг бэрхшээлийн төрлөөс нь хамаарч, элсэлтэнд хамруулах арга замыг эрэлхийлэх.

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Зөвлөн туслах үйлчилгээ нь суралцагчийн хэрэгцээ, сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд чиглэсэн байна.
- Оюутны алба ажилладаг. /Мэргэжил бүрийн төлөөлөл болох 10 гаруй оюутны бүрэлдэхүүнтэй ба үүнээс 1 оюутан сувилахуйн ангиас сонгогдож, сургалтын тэтгэлэг авдаг байна.
- Сувилахуйн анги бүр зөвлөх багштай, үйл ажиллагаа нь зөвлөх багшийн журам /2015 оны 233 тоот тушаал/-аар зохицуулагддаг.
- Оюутны дадлага хийх “Дадлагын нэгдсэн удирдамж”-тай. /Оюутны ярилцлагаас: зарим улирлын бүх хичээлээр 1 гарын авлага гаргасан байна./

- Оюутанд зөв хүмүүжил олгох, манлайлах, ур чадвартай мэргэжилтэн болж төлөвших, бусдыг хайрлан хүндлэх, хамтран ажиллах зорилгоор БНСУ-ын Сөүлийн Эмэгтэйчүүдийн их сургуулийн дэргэдэх “Барум” сургалтын төв, Оюутны албатай хамтарсан “Хувь хүний хөгжил” сургалт зохион байгуулдаг.
- “Хувь хүний хөгжлийн сургалт” ажилладаг. 2014 оноос хойш Сэтгэл судлал, гэр бүлд зөвлөгөө өгөх төвөөр гэр бүл болон сэтгэлзүйн зөвлөгөө өгч ажилладаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- “Хувь хүний хөгжлийн сургалт”-ыг 2014 оноос хойш жил бүрийг 8-р сард зохион байгуулж хэвшсэн ба сувилахуйн оюутнууд 2015-2016 онд 38, 2016-2017 онд 31, 2017-2018 онд 52, 2018-2019 онд 14 хамрагдсан.
- Сувилахуйн оюутны дадлага хийх “Дадлагын нэгдсэн удирдамж”-тай.
- Сэтгэл судлал, гэр бүлийн зөвлөгөө өгөх төвөөр 2015 онд 5, 2016 онд 10, 2017 онд 5, 2018 онд 12, 2019 онд 2, 2020 онд 3 оюутан, нийт сувилахуйн 42 оюутан зөвлөгөө авсан байна.

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

Оюутны олон нийтийн үйл ажилд оролцсон байдал, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг. Ерөнхий захирлын “Оюутанд олгох тэтгэлгийн журмыг шинэчлэн батлах тухай” 222-р тушаалд үндэслэн оюутны сургалтын чанарыг сайжруулах нийгмийн халамж, амьдралын нөхцөл байдалд туслах зорилгоор тэтгэлэг олгодог:

- Захирлын нэрэмжит тэтгэлэг
- Удирдах зөвлөлийн тэтгэлэг
- Едам тэтгэлэг
- Ид шидийн орон Хүүхэд хөгжил хамгааллын төвд сайн дурын хандив өгсөн тайлан
- Солонгос /Ёнсей, Кушин ИС-ын 20-30 оюутан/, монгол сувилахуйн оюутнуудтай хамт Тэрэлжид ажилласан тайлан
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажилласан тайлан

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Оюутны хөдөлмөр эрхлэлт явуулж, семестрийн сургалтын төлбөрийн хөнгөлөлтөөр тооцдог нь тэдний санхүүгийн тогтвортой байдлыг

хангахад чиглэдэг. Оюутны сайн дурын ажлыг зохион байгуулахад дэмжин ажилладаг.

- “Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв”-ийг 2013 оноос байгуулан цагийн ажил, оюутны хөдөлмөр эрхлэлт явуулдаг. /багшийн ажилд туслах, анги танхим цэвэрлэх г.м 1 семестрт 60 цаг ажиллаад 1 семестрийн сургалтын төлбөрийн 30%-ийн хөнгөлөлт эдэлдэг. /**147 оюутан 73.549.150 төг**/
- Захирлын нэрэмжит тэтгэлэг /Семестр бүрт 1 оюутан
- Удирдах зөвлөлийн тэтгэлэг /Семестр бүрт 1 оюутан
- Едам тэтгэлэг /сургалтын тэтгэлэг - сувилахуйн чиглэлээр Канад, АНУ-д магистр, PhD хамгаалсан сувилагч нар хандив босгодог/ - 2015-2019 оны байдлаар 50 оюутан авсан байна. /У Га Шил багшийн тэтгэлэг/
- 2015 оноос хойш сувилахуйн ангийн нийт **123 оюутан** /2015-2016 онд 54, 2017 онд 23, 2018 онд 6, 2019 онд 40/ тэтгэлэгт хамрагдсан байна.
- Ид шидийн орон Хүүхэд хөгжил хамгааллын төвд сайн дурын хандив өгсөн. /1-4 курс, магистрын ангийн оюутнууд, багш нар нийлээд 201.000 төг болон хувцас хандивласан.
- Солонгос /Ёнсей, Кушин ИС-ын 20-30 оюутан/, монгол сувилахуйн оюутнуудтай хамт Тэрэлжид амьдрах айл, хүмүүст /50-60 хүн/ эрүүл мэндийн үзлэг хийж, зөвлөгөө өгдөг.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажилладаг /2017 оноос хойш 4-5 оюутан/ Аутизмтай, дауны синдром, оюуны хомсдол, тархины саажилттай хүүхдүүдтэй харилцаж, сайн дурын ажил хийдэг.

Зөвлөмж:

- Сувилагчийн олон нийтийн үйл ажиллагааг албажуулан баталгаажуулж ажиллах.

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

- Оюутны шилжилт хөдөлгөөнийг 2018 оны “Шилжилт хөдөлгөөнийг шилжүүлэх журам”-аар зохицуулдаг.
- 2018 оны “Шилжилт хөдөлгөөнийг шилжүүлэх журам”
- “Оюутны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах журам” ОУУБИС-ийн захирлын А/58 тоот тушаал-аар зохицуулдаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сувилахуйн оюутнууд сүүлийн 5 жилийн байдлаар эрх сэргээсэн 213, шилжиж ирсэн 12, жилийн чөлөө авсан 78, сургуулиас гарсан 64, улирсан

90/ Шалтгаан: санхүүгийн чадваргүй, ар гэрийн гачигдал, гэр бүл зохиосон, хүүхэд харах хүнгүй, гадагшаа суралцахаар явсан г.м байна. 2014-2019 оны хичээлийн жилд суралцагчийн шилжилт хөдөлгөөний тайлангаас харахад суралцаж байгаа оюутны тоотой харьцуулахад шилжилт хөдөлгөөн их байгаа нь мэргэжлийн сонголт зөв эсэх, нэгэнт элссэн оюутантай ажиллах зөвлөх багш нарын үйл ажиллагаатай холбоотой байна.

Анхаарах асуудал:

- Зөвлөх болон тэнхмийн мэргэжлийн багш нар оюутны шилжилт хөдөлгөөнд судалгаа гарган ажилладаг ч элсэж орсон оюутны тооноос давсан шилжилт хөдөлгөөн тайланд тусгагдсан байна.

Зөвлөмж:

- Зөвлөх багш оюутнуудтай мэргэжлийн мөн чанар, үнэ цэнэ, хэрэгцээтэй мэргэжил болох талаар байнга зөвлөж, ажиллах.
- Анги удирдсан зөвлөх багш болон тэнхмийн мэргэжлийн багш нар оюутны шилжилт хөдөлгөөн дээр нарийн судалгаа гарган ажиллаж, шилжилт хөдөлгөөн хамгийн бага байх боломжит нөхцлийг эрэлхийлэн ажиллах.

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- Төгсөлтийн үйл ажиллагаа явуулахдаа батлагдсан дүрэм, журамд үндэслэдэг.
- БСШУС-ын “Боловсролын баримт бичгийн загвар шинэчлэн батлах тухай” А/78 тоот тушаал
- ОУУБИС-ийн “Эрдмийн зөвлөлийн хурал”-ын 2015 оны 10 сарын 21-ний өдрийн тогтоолоор баталсан “Сургалтын журам”
- ОУУБИС-ийн Ерөнхий захирлын 2015 оны 11 сарын 19-ний өдрийн №235 тоот тулаалаар баталсан “Оюутныг төгсгөх журам”
- “Төгсөлтийн шалгалтын журам” зэргийг үндэслэн төгсөлтийн үйл ажиллагаа зохион байгуулдаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Гадаадын ижил төстэй сургуульд оюутан солилцооны сургалт, дадлага хийлгэдэг. Дээд боловсролтой бакалаврын зэрэгтэй “Мэргэжлийн

диплом” нь сургалтын төлөвлөгөөнд тусгасан хичээлүүдэд хангалттай үнэлгээ (голч үнэлгээ С-ээс дээш) авсан нөхцөлд олгодог байна.

Зөвлөмж:

- Голч дүн хангалттай түвшинд байгаа сувилахуйн ангийн оюутанг дипломын ажил бичиж хамгаалах боломжийг судлах.

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

- Сувилахуйн хөтөлбөрийн зорилго, зорилт, түүнд тавигдах шаардлагад нийцсэн багшийг сонгон шалгаруулж авахад Дээд боловсролын тухай хуулийн 13.1 болон 13.2-д заасан ерөнхий шаардлага
- Ерөнхий захирлын 2015 оны 12 сарын 15-ны 252 тоот тушаалын хавсралтаар баталсан “ОУУБИС-ийн профессор багш ажиллуулах журам”-ыг ханган ажилладаг.
- Сувилахуйн хөтөлбөрт хичээл заадаг үндсэн 7 багш байгаагаас 3 нь PhD-тай, магистр 4 багш байгаа нь нийт багш нарын 57% нь эрдмийн зэрэг цолтой байна. /2019 онд тус тэнхимд профессор 1, дэд профессор 2, багш 4, зочин профессор 1 /Куши ИС-ийн багш Чүй Ын Жон/, цагийн багш 4, 1 менежер ажилладаг байна./
- Багшийг сонгон шалгаруулахдаа сургалтын албаар дамжуулан тэнхим тодорхойлж, нээлттэй мэдээллийн сүлжээ, сургуулийн вебсайтад зар байршуулдаг байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сувилахуйн хөтөлбөрт хичээл заадаг үндсэн 7 багш байгаагаас 3 нь PhD-тай, магистр 4 багш байгаа нь нийт багш нарын 57% нь эрдмийн зэрэг цолтой байна. 2019 онд тус тэнхимд профессор 1, дэд профессор 2, багш 4, зочин профессор 1 /Куши ИС-ийн багш Чүй Ын Жон/, цагийн багш 4, 1 менежер ажилладаг.
- Хөтөлбөр хэрэгжүүлэгч тэнхимийн багш нарын хувьд 1 багшид ноогдох оюутны тоо 2019 оны байдлаар 14 байна.

Анхаарах асуудал:

- Нэг багш 3-5 төрлийн хичээл зааж байгааг анхаарч, хөтөлбөрийн чиглэлээр мэргэшсэн багшийн тоог нэмэгдүүлэх шаардлагатай.

Зөвлөмж:

- Сувилахуйн чиглэлээр мэргэшсэн, магистр ба түүнээс дээш эрдмийн зэрэг цолтой мэргэжлийн багшаар хүний нөөцөө тэлэх.

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

- ОУУБИС-ийн эрдмийн зөвлөлийн 2014 оны 8 сарын 26-ны хурлын тогтоол, ерөнхий захирлын А/16 тоот тушаалаар батлагдсан “Улаанбаатар их сургуулийн багш нарыг хөгжүүлэх хөтөлбөр”
- 2019-2020 оны хичээлийн жилд “Багшийн хөгжил, эрдэм шинжилгээний төв” байгуулагдсан
- Багшийн мэргэжил, ур чадварыг гадаад (БНСУ, БНХАУ, ОХУ), дотоодын их сургуулиудад урт богино хугацаагаар мэргэжил дээшлүүлэх, судалгааны ажлын үр дүнг хэлэлцүүлэх нөхцлийг бүрдүүлдэг нь багш нарын үнэмлэхээр нотлогдож байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**Онцлог зүйл/Туршлага:**

- 2015-2021 он хүртэл стратеги гаргасны дагуу багш бүр хөгжлийн төлөвлөгөөг 5 жилээр гаргасан байна.
- “Багшийн хөгжил, эрдэм шинжилгээний төв” байгуулагдснаар Багшийн хөгжлийн төлөвлөгөөг а) эрдэм шинжилгээ судалгааны ажил, б) багшийн мэргэжил дээшлүүлэх, с) сурган заах арга, d) гадаад хэлний боловсрол, e) өөрийгөө хөгжүүлэх чиглэлээр 3 үе шаттай гарган хэрэгжүүлдэг байна.
- Хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нар БНСУ-ын 4 их сургуульд 2016 оноос хойш 100% 14 хоногоос 2 жилийн хугацаанд мэргэжил дээшлүүлсэн. Багшийн мэргэжил, ур чадварыг гадаад (БНСУ, БНХАУ, ОХУ), дотоодын их сургуулиудад урт богино хугацаагаар мэргэжил дээшлүүлж, судалгааны ажлын үр дүнг хэлэлцүүлэх нөхцлийг бүрдүүлдэг байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нарын өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөө, тайлан ерөнхий, товч байна.
- Багшийг суралцах боломжоор хангах, судалгааны ажил, төсөл хэрэгжүүлэхэд сургуулийн удирдлагын зүгээс тогтвортой урамшуулах грант олгох, дэмжин ажиллах.

Зөвлөмж:

- Багш хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахдаа “Багшийн хөгжлийг дэмжих тухай” 2018 оны 6 сарын 27-ны өдрийн хууль, “Багшийн хөгжлийг дэмжих талаар авах зарим арга хэмжээний тухай” МУ-ын ЗГ-ын тогтоолыг үндэс болгон бодитой, тодорхой боловсруулах, тайланг тодорхой, дэлгэрэнгүй бичих /гадаад, дотоодын сургалт, судалгааны сургалт, бүтээл хэвлүүлсэн г.м. Тайлан, үр дүн/
- Мэргэжлийн үндсэн сурах бичгийг багаараа хамтран гаргах хэрэгтэй.
- Багш судалгааны ажил хийх, төсөл хөтөлбөр дээр ажиллахад удирдлагын зүгээс дэмжих.

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- 2015 оноос багш нарын эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл, ном сурах бичиг, оюуны өмчийн бүтээлүүийг цахимжуулж www.research.ubu.mn мэдээллийн системд оруулдаг байна.
- Сувилахуйн магистрын хөтөлбөр хэрэгжүүлэх олон улсын (БНСУ-ын Ёнсей ИС, Бангладеш улсын сувилахуйн сургууль) төсөлд хамтран ажилласан (У Га Шил) байна.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нар БНСУ-ын Чусон ИС, АШУУИС, МҮИС-ийн багш нартай хамтран “Сувилахуйн үндэс” сурах бичгийг боловсруулсан. 2015-2019 онуудад тус тэнхмийн 7 багш ОУ-ын чанартай сургалт семинарт сургуулийн санхүүжилтээр оролцсон байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч тэнхмийн багш нар 2016 оноос хойш эрдэм шинжилгээний өгүүлэл 22, илтгэл 25, гарын авлага 15, ном сурах бичиг 8, зохиогчийн эрх 4-ийг бүтээл болгон ашиглаж байна.

Анхаарах асуудал:

- Гадаад, дотоодын ямар сэтгүүлд, ямар сэдэвт бүтээл хэвлэгдсэнийг тодорхой болгох.
- Багш нарын хийсэн эрдэм шинжилгээний бүтээлийн үр дүн багшлах ур чадвар, сургалтын арга зүйтэй уялддаг байх.

Зөвлөмж:

- Багш нар хийж буй эрдэм судалгааны ажлын цар хүрээг тэлэх: /багийн судалгаа – сургалт, эмнэлзүйн, туршилт г.м, мэргэжлийн сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх, гадаадын IF-тай сэтгүүл, scopus-д бүртгэлтэй

сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх, тухайн бүтээл нь Н индекст ишлэгдсэн байх/

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

- Багшийг үнэлдэг /сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, нийгмийн үйлчилгээний ажил/ бүлэг шалгуур үзүүлэлт
- Ерөнхий захирлын тушаалаар томилогдсон “Багш аттестатчилах комисс”
- Сургалтын албанаас гаргасан “Багшийн ажлын дэвтэр”

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багш нарыг 2015-2016 оны хичээлийн жилээс эхлэн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, нийгмийн үйлчилгээний ажил гэсэн бүлэг шалгуур үзүүлэлтүүдээр үнэлдэг ба ерөнхий захирлын тушаалаар томилогдсон “Багш аттестатчилах комисс” дүнг нэгтгэн гаргаж, цалин хөлс нэмэх, шагнал уламшуулалд дэвшүүлдэг байна. Энэ хүрээнд шалгуулагч багш өөрийн үйл ажиллагааны тайлан хамгаалж, гадаад хэл, сурган, сэтгэл судлал, мэргэжил гэсэн үзүүлэлтүүдээр дүгнэдэг байдал нь үнэлгээний тогтолцоо хэрэгждэг болохыг харуулж байна.
- Сургалтын алба нь багш бүрийн “Багшийн ажлын дэвтэр”-ийг улирлын эцэст хураан авч, цагийн тооцооны хуудастай тулган үзэж, хяналт тавьдаг. Хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нарын талаарх /сургалтын үйл ажиллагаа, мэргэжлийн ур чадвар/ оюутны сэтгэл ханамжийн судалгаа аван, сургалтын үйл ажиллагаанд үнэлгээ хийж хэвшсэн байна.

Анхаарах асуудал:

- Багшийн үнэлгээний дагуу хийсэн судалгааны үр дүн, авч хэрэгжүүлсэн ажил тодорхой бус байна.

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтыг хангах удирдлага, зохион байгуулалтын шийдэл, үйл ажиллагааны схем
- Төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгаа, 2019-2020 он
- Ажил олгогчийн сэтгэл ханамжийн судалгааны тайлан, 2019-2020 он
- Оюутны сэтгэл ханамжийн судалгаа, түүний үр дүн, тооцоолол, 2017 он
- Эцэг эхийн сэтгэл ханамжийн судалгаа

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан**Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөрийн нэгжээс оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизм бүрдүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж эхэлж байна. Сувилахуйн мэргэжлийн хөтөлбөрийг боловсруулах, шинэчлэх ажлыг мэргэжлийн тэнхим, багш нар хариуцан хийж байгаа бөгөөд 2014 оноос уг ажил эрчимжсэн, 2019 оноос хэрэгжилтийн үр дүнд хяналт тавих ажил хийгдэж эхэлсэн, сайжрах боломжтой байна.
- ОУУБИС-ийн Сургалтын журам болон Хөтөлбөрийн хорооны журамд заасны дагуу хөтөлбөрийн дэд хороо нь хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилтэнд (дотоод баталгаажуулалтын хүрээнд) хичээлийн улирал, жилээр хяналт тавьж үр дүнг сургуулийн удирдлага, хөтөлбөрийн ерөнхий хороонд тайлагнадаг.
- Хөтөлбөрийн талаарх оролцогч болон сонирхогч талуудын саналыг санал асуулгын судалгаагаар тодорхой хэмжээнд авч хэвшсэн ба судалгааны үр дүнг гаргадаг.
- Мэргэжлийн нийгэмлэг холбоодтой хамтран ажилладаг, ажлын тайлан мэдээ тогтмол гаргадаг байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын үйл явцыг эрчимжүүлэхэд анхаарах.
- ЧДБ-ын бодлого, журам, хөтөлбөр, төлөвлөлт тодорхой бус.
- Хөтөлбөрийн хороонд оролцогч, сонирхогч талуудын төлөөллийг бүрэн оролцуулдаггүй.

Зөвлөмж:

- ЧДБ-ын бодлого, журам, хөтөлбөр, төлөвлөлтийг илүү тодорхой болгох.

Шаардлага:

- ЧДБ-ын бодлогоо тодорхойлох, түүнийг дагаж гарах журам боловсруулах, дунд, богино хугацаанд хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөлтийн үр дүнг хэмжигдэхүйц байхаар боловсруулах.

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

Илрэл нотолгоо:

- Сувилахуйн тэнхимийн 2015-2019 оны лицензийн шалгалтын үр дүн
- Мэргэжлийн холбоодтой хамтран ажилласан ажлын тайлан
- Төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгаа, 2019-2020 он
- Хөтөлбөрийн үр дүнгийн судалгаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Төгсөгчдийн ажил эрхлэлт, ажлын байрны нийцлийн судалгааг 2017-2019 оны байдлаар хийхэд 93 хувь нь нийцтэй гэсэн үр дүн гарсан.
- Төгсөгчдийн карьер өсөлтийн судалгааг 2011-2014 онд төгссөн 10 төгсөгчөөс авсан. Төгсөгчдийн 90,5 хувь нь сар хүрэхгүй хугацаанд ажлын байраар хангагддаг байна.
- Оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгааг авч хэвшсэн, үр дүнд тодорхой хэмжээнд шинжилгээ хийдэг, тайлагнадаг /Ажил олгогч, мэргэжлийн холбоод, төгсөгч гэх мэт/.
- Дараагийн шатны хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцах боломж сайн, хөнгөлөлт, тэтгэлэг олгодог, ҮГД-ийн шалгуур хангасан төгсөгчдөд суралцах эрхийн бичиг гардуулдаг. Хөтөлбөрийн үр дүнгийн судалгааг гаргадаг.

Анхаарах асуудал:

- Ажил олгогч, төгсөгч, оюутан, багш, эцэг эхийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг хөтөлбөрт хэрхэн тусгадаг нь хэмжигдэхүйц бус.
- Дотоод, гадаадын дараагийн шатны хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцаж буй төгсөгчдийн эзлэх хувь бага.
- Судалгааны үр дүнгийн зөрүүтэй байдлыг арилгах, боловсруулалтыг сайжруулах.

Зөвлөмж:

- Төгсөгчдийн карьер өсөлтийн судалгаа, дүгнэлт, үр дүнг нийт төгсөгчдийн хэмжээнд гаргаж хэвших.
- Төгсөгчдийн ажлын байраар хангагдах хүртэлх хүлээх хугацааны судалгаа, шинжилгээг тогтмол хийж хэвших.
- Дотоод, гадаадын дараагийн шатны хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцаж буй төгсөгчдийн хувийг нэмэгдүүлэх.

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Сувилахуйн тэнхимийн 2015-2019 оны лицензийн шалгалтын үр дүн
- Сувилахуйн мэргэжлийн магистрын сургалтын хөтөлбөрийн урьдчилсан үнэлгээний тайлан, шинжээчийн багийн үнэлгээний тайлан
- Мэргэжлийн холбоодтой хамтран ажилласан ажлын тайлан
- Төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгаа, 2019-2020 он

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**Онцлог зүйл/Туршлага:**

- ОУУБИС-ийн Сувилахуйн хөтөлбөр нь энэ жил дотооддоо улмаар БНСУ-ын сувилахуйн хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд орохоор төлөвлөн ажиллаж байгаа.
- Хөтөлбөр төлөвлөсөн үр дүндээ хүрсэн эсэхийг тодорхойлох шалгуур нь сувилах эрх авах шалгалт бөгөөд энэ нь мэргэжлийн байгууллагаас өгөх хөндлөнгийн үнэлгээ болдог.
- Хөтөлбөрөөр төгсөгчдийг мэргэжлийн салбарт хүлээн зөвшөөрсөнийг нотлох баримт бичгийн судалгаатай.
- Сувилахуйн мэргэжлээр төгсөгчдөөс Төмөртоогоо овогтой Цолмон Солонгос улсад Эйчплас Янгжи эмнэлэгт сувилагч мэргэжлээрээ ажиллаж байгаа, Чимэдбалжир овогтой Балжинням Герман улсын “Kulrtuakademie Dresden” сургуульд сувилагчийн шалгалтаа өгч тэнцээд “Renha-Klinik Hetzdorf” Сэхээн амьдруулах тасагт 10 сар ажиллаж байгаад одоо “Seniorenheim Freiberg” гэдэг ахмадын асрамжийн газар сувилагчаараа ажиллаж байгаа сайн үр дүнгүүд байна.

Анхаарах асуудал:

- Олон улсын болон гадаадын хөрөнгө оруулалттай байгууллага болон гадаадад ажиллаж буй төгсөгчдийн тоог нэмэгдүүлэх.

Зөвлөмж:

- Дотоод болон олон улсын хэмжээнд хөтөлбөрөө хүлээн зөвшөөрүүлэхүйц хэмжээнд хүртэл сайжруулах, боловсруулах, бэлтгэлийг тасралтгүй хангах.

7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

ДҮГНЭЛТ

Шалгуур	Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангааг үй (0)	Үндэслэл, шалтгаан

1	Хөтөлбөрийн төлөвлөлт /3/	3	-	-	
2	Сургалтын үйл ажиллагаа /3/	2	-	-	
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, нөөц /3/	2	3.2	-	3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт /5/	4	4.3	-	4.3. Санхүүжилт
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа /5/	5	-	-	
6	Багшлах үйл ажиллагаа /4/	4	-	-	
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт /3/	2	7.1	-	7.1.Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт
	Нийт - 26	22	4		
Дүгнэлт		Бүрэн хангасан			

ЕРӨНХИЙ ЗӨВЛӨМЖ

1. Сургалтын хөтөлбөрийн нийгмийн эрэлт хэрэгцээ, оролцогч болон сонирхогч талуудаас авсан сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг үндэслэж, хичээлийн агуулга, төгсөгчийн эзэмших мэдлэг, чадвар, хандлагыг харьцуулж, хөтөлбөрийн сайжруулалт хийх
2. Сургалтанд виртуал лаборатори, case application, аудио, видео, подкаст, аудио визуал тест зэрэг дэвшилтэт аргуудыг ашиглах
3. Сувилагч мэргэжлээр элсэлтийн бодлого, маркетингийн төлөвлөгөөтэй байх. ЭМЯ, ХНХЯ-ны эрэлт хэрэгцээнд үндэслэх
4. Багшийг судалгааны ажил хийх, төсөл хөтөлбөр дээр ажиллахад удирдлагын зүгээс дэмжих, багшийн хийж буй эрдэм судалгааны ажлын цар хүрээг тэлэх /багийн судалгаа–сургалт, эмнэлзүйн туршилт г.м, өгүүлэл хэвлүүлэх, гадаадын IF-тай сэтгүүл, scopus-д бүртгэлтэй сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх/
5. Оюутны суралцах таатай орчинг бүрдүүлэх: эмнэлгийн дадлагын сургалтанд зориулж хувцас солих локероор хангах, сувилахуйн ур чадварын өрөөнд /лабораторид/ халдвар хамгааллын дэглэмийн журмыг сахих, гардан ажилбарын сургалтын хэрэглэгдэхүүнээр хангаж ажиллах
6. Сувилахуйн сургууль, хөтөлбөрийн онцлогийг харгалзсан санхүү, төсвийн төлөвлөлтийг хийдэг болох, бие даан ажиллах боломжийг бүрдүүлэх

7. Бүх шатны төлөвлөлт, үр дүнгийн уялдаа холбоог хангах

ДҮГНЭЛТ

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Олон улсын Улаанбаатарын их сургуулийн Сувилахуйн сургуулийн “Сувилахуй” хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “Шалгуурыг бүрэн хангасан” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Эрүүл мэндийн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг /Д.Солонго/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг..... /Б.Энхтуяа/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг..... /Б.Оюунцэцэг/

IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

№	Нэр	Албан тушаал	Зэрэг цол	Ажилласан жил	Заадаг хичээл
1	Б.Буянхишиг	Сувилахуйн тэнхимийн эрхлэгч	Доктор, дэд		Биологи, хими, биохими
2	Ц.Оюундарь	Ахлах багш	Доктор, дэд	30 жил	Сувилахуйн удирдлага,
3	Л.Дондоосүрэн	Багш	СУ-ны магистр	25 жил	Хамт олны сувилахуй
4	Б.Оюунбилэг	Багш	СУ-ны магистр	11 жил	Насанд хүрэгсдийн сувилахуй, ЭМ-ийн үнэлгээ
5	А.Амаржаргал	Багш	СУ-ны магистр	6 жил	Халдвартын сувилахуй, СУА
6	Б.Нямбаяр	Багш	СУ-ны магистр	4 жил	Хүүхдийн сувилахуй
7	Б.Лхагва-Эмгэн	Мэргэжилтэн	магистрант	1 жил	-

II. Оюутны нэрс

		оюутны нэр	оюутны код	тайлбар
1	1-р курс	М.Онон	nu20d014	хөдөө/ ангийн дарга
2		Д.Түмэнуянга	nu20d001	идэвхитэй
3		О.Эрдэнэцэцэг	nu20d003	төрийн сан
4		Б.Айбота	nu20d008	казак
5		Б.Нармандах	nu20d009	хөдөө/ Н-үйлчлэл
6	2-р курс	Алтанзул	nu19d008	оюутны зөвлөл
7		Мөнхтуяа	nu19d003	хандлага сайн
8		Өүлэн	nu19d009	хандлага сайн
9		Номинзул	nu19d001	хандлага сайн
10	3-р курс	Учрал	nu18d014	хөдөө
11		Содончимэг	nu18d010	хандлага сайн
12		Лхамдарь	nu18d004	хөдөө
13		Ганцэцэг	nu18d013	хандлага сайн
14		Мөнхчимэг	nu18d002	ангийн дарга
15	4-р курс	Отгонцэцэг	FL16d032	нийгмийн идэвхи
16		Цэдэвсүрэн	nu17d003	хөдөө, эрэгтэй
17		Б.Баярмаа	nu17d030	сайн дурын ажил
18		Б.Зулаа	nu17d013	хандлага сайн
19		Г.Анужин	nu17d002	төрийн сан

III. Ажил олгогчдын нэрс

№	Овог нэрс	Байгууллага	Албан тушаал
1	Д.Пүрэвдаваа	ЭХЭМҮТ	Сувилгааны албаны дарга
2	Г.Бор	ХӨСҮТ	Сувилгааны албаны дарга
3	Д.Дуламсүрэн	ХСҮТ	Сувилгааны албаны дарга
4	Н.Эрхүү	УХТЭ	Сувилгааны албаны дарга
5	Д.Оргилмаа	СЭМҮТ	Сувилгааны албаны дарга
6	Д.Нацагсүрэн	БГДЭМТ	Сувилгааны албаны дарга
7	Д.Өлзийжаргал	Интермед эмнэлэг	Сувилахуй эрхэлсэн захирлын үүрэг гүйцэтгэгч
8	Ш.Цэрмаа	Натул эмнэлэг	Сувилгааны албаны дарга
9	М.Оюунтуул	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн СЗҮТ	Сувилгааны албаны дарга

IV. Төгсөгчдийн нэрс

№	Овог нэрс	Төгссөн он	Байгууллага, албан тушаал
1	Г.Ганчимэг	2012	Зинт клиник
2	А.Роза	2019	Монгол Кампус Крусайд ТББ
3	Б.Отгонболь	2019	ШНУГТЭ- Эрчимт эмчилгээний сувилагч
4	Б.Мөнхсолонго	2018	ХӨСҮТ- СК-Эрчимт эмчилгээний сувилагч
5	Х.Болор-Эрдэнэ	2018	Япон-Монголын хамтарсан эмнэлэг сувилагч
6	Э.Алтанчимэг	2016	Гурван гал эмнэлэг сувилагч
7	С.Оюунсүвд	2016	УНТЭ-Бөөрний тасагт сувилагч
8	Т.Энхзаяа	2014	Топаз эмнэлэг хүний нөөцийн албаны дарга
9	Д.Баасанжаргал	2014	Агапе эмнэлэгт сувилагч
10	Н.Нямбат	2015	Натул эмнэлэг мэдээгүйжүүлгийн сувилагч
11	М.Номингэрэл	2011	СЭМҮТ- сувилагч

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал
/албан бичгийг оруулах/



БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН
ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛД

**ОЛОН УЛСЫН УЛААНБААТАРЫН
ИХ СУРГУУЛЬ**

210644 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг
Намянжүгийн гудамж, Утас: 462046 Факс: 976-11-462040
E-mail: info@iuu.edu.mn, iuu.edu.mn

2020.12.30 № 1/439

танай _____-ны № _____-т

**ШИНЖЭЭЧИЙН БАГИЙН ӨГСӨН НЭМЭЛТ
ТАЙЛБАРТ ХАРИУ ӨГӨХ НЬ**

Тус сургуулийн “Сувилахуй” хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн мэргэжлийн шинжээчдийн дүгнэлтэнд хөтөлбөрийн багийн зүгээс урьдчилсан тайланд тайлбар хийсэн шалтгаан нь шинжээчдийн өгсөн дүгнэлт, санал зөвлөмж, анхааруулах зүйлийг хүлээн зөвшөөрөөгүйдээ биш юмаа. Зөвхөн бид бүгдийн зүгээс өөрийн үнэлгээний тайланд байгаа зүйлийг дахин нэг тодруулж харахыг хүсэлт байдлаар тайлбар бичсэн гэдгийг юуны өмнө та бүхэн ойлгож өгнө үү!

Өөрийн үнэлгээний тайлангийн 7 шалгуурын дагуу өгсөн шинжээчдийн нэмэлт тайлбар, санал зөвлөмж, дүгнэлтийг бид хүлээн зөвшөөрч байна.

Цаашдаа бид бүхэн хөтөлбөрөө сайжруулан, чанарын баталгаажуулалтаа тогтмол хийж байхад анхаарч ажиллана.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



ЦОЙ ГИ ХО